

**МОНГОЛ-ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ**  
**“УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ”**



**ЭМ, ЭМНЭЛЭГИЙН ХЭРЭГСЭЛ,  
ОНОШЛУУР ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ**

Тендер  
шалгаруулалтын  
нэр:

**Эм, эмнэлэгийн хэрэгсэл, оношлуур худалдан авах  
тендер шалгаруулалт**

Тендер  
шалгаруулалтын  
дугаар:

**УБТЗТЭ /20240102001/**

**Улаанбаатар хот**

**2024 он**

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	1
1. Тендерийн цар хүрээ.....	1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	1
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ.....	2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах.....	3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	3
11. Тендерийн иж бүрдэл.....	4
12. Тендерийн жишиг маягтууд.....	5
13. Хувилбарт санал.....	5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	5
16. Чадавхын болон туршлагын шаардлага.....	7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт....	8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	8
20. Тендерийн валют.....	9
21. Тендер хүчинтэй байх хугацаа.....	9
22. Тендерийн баталгаа.....	9
23. Тендер баталгаажуулах, илгээх.....	9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	10
25. Тендерийн талаар тодруулга авах.....	10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	10
27. Тендерийг үнэлэх.....	10
28. Арифметик алдааг залруулах.....	10
29. Оролцогчид давуу эрх олгох.....	11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....	11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	11
32. Тендерийг эрэмбэлэх.....	11
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах.....	11

34.	Мэдэгдэл хүргүүлэх.....	11
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	12
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	12

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
  - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
  - 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
  - 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
  - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж
  - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан авах ажиллагааны цахим систем
  - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх
  - 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.



- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20<sup>1</sup>, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч этгээд, оролцогч**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл**
- 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.

#### **Б.АГУУЛГА**

**9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:  
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;  
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;  
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;  
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;  
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;  
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

**11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

**В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

### **13. Тендерийн иж бүрдэл**

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
  - 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
  - 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
  - 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
  - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
  - 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
  - 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
  - 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
  - 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
  - 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
  - 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн маягтууд жишиг** 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал** 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг** 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;
- 16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг** 17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.
- 17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

- 17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.
- 17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.
- 17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.
- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 18. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.
- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.



- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

#### **Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ**

- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.
- 29. Тендерийг үнэлэх**
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.
- 30. Арифметик алдааг залруулах**
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

- 31. Давуу эрх олгох**
- 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг магадлах дахин**
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

- 36. Шийдвэр хүргүүлэх**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн  
баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг  
зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

<b>ТШЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</b>
<b>ТШЗ 1.1</b>	Захиалагч: <b>Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “УБТЗ”-ын “Төв Эмнэлэг”</b>
<b>ТШЗ 1.2</b>	Тендер шалгаруулалтын нэр: <b>“Эм, эмнэлэгийн хэрэгсэл, оношлуур” худалдан авах</b>
<b>ТШЗ 1.3</b>	Тендерийн урилгын дугаар: <b>УБТЗТЭ/20240102001/</b>
<b>ТШЗ 1.4</b>	<p>Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b>Багц № 1: Сэтгэц нөлөөт ,мансууруулах эмүүд</b></p> <p><b>Багц № 2: Мэдээгүйжүүлэх эмүүд</b></p> <p><b>Багц №3: Зүрх судасны системд нөлөөлөх эмүүд</b></p> <p><b>Багц №4: Антибиотик, мөөгөнцөрийн эсрэг эмүүд</b></p> <p><b>Багц №5: Антибиотик</b></p> <p><b>Багц №6: Өвдөлт намдаах, үрэвслийн эсрэг эмүүд</b></p> <p><b>Багц №7: Судсаар сэлбэх шингэнүүд</b></p> <p><b>Багц №8: Артерийн даралт бууруулах, хаван хөөх эмүүд</b></p> <p><b>Багц №9: Хоол боловсруулах, элэг цэсний үйл ажиллагаанд нөлөөлөх эмүүд</b></p> <p><b>Багц №10: Витамин, уураг, амин хүчил</b></p> <p><b>Багц №11: Нэг удаагийн тариур зүү</b></p> <p><b>Багц №12: Амьсгалын замын үрэвсэл, харшлын болон вирусын эсрэг хэрэглэх эмүүд</b></p> <p><b>Багц №13: Цус алдалтын эсрэг эмүүд</b></p> <p><b>Багц №14: Тархины цусан хангамж сайжруулах эмүүд</b></p> <p><b>Багц №15: Нэг удаагийн хэрэгсэл</b></p> <p><b>Багц №16: Хагалгааны хэрэгсэл</b></p> <p><b>Багц №17: Ариутгал, халдваргүйтэлийн бодисууд</b></p> <p><b>Багц №18: Наркозын унтуулгын хэрэгсэл</b></p>

	<p><b>Багц №19: Уламжлалт эмчилгээний хэрэгсэл</b></p> <p><b>Багц №20: Лабораторийн нэг удаагийн хэрэгсэл</b></p> <p><b>Багц №21: Индикатор, ариутгал, халдваргүйтэлийн бодисууд</b></p> <p><b>Багц №22: Рентгений хальс</b></p> <p><b>Багц №23: Дурангийн хагалгааны хэрэгсэл</b></p> <p><b>Багц №24: Дурангийн хагалгааны утас</b></p> <p><b>Багц №25: Мэс заслын хагалгааны утас</b></p> <p><b>Багц №26: Түнх өвдөгний дурангийн хагалгааны хэрэгсэл</b></p> <p><b>Багц №27: Гар сарвууны дурангийн хагалгааны хэрэгсэл</b></p> <p><b>Багц №28: Шүдний материалууд</b></p> <p><b>Багц №29: Эмгэг судлалын будагч бодис, нэг удаагийн хэрэгсэл</b></p> <p><b>Багц №30: Цусны бүлэг, бүлэгнэлтийн оношлуурууд</b></p> <p><b>Багц №31: Латекс оношлуур, түргэвчилсэн тест</b></p> <p><b>Багц №32: Гематологийн урвалж бодис</b></p> <p><b>Багц №33: Биохимийн бүрэн автомат анализаторийн урвалж бодис</b></p> <p><b>Багц №34: Иммунологийн урвалж бодис</b></p> <p><b>Багц №35: Молекул биологийн урвалж хэрэгсэл</b></p> <p><b>Багц №36: Иммунологийн хагас автомат анализаторийн урвалж бодис</b></p> <p><b>Багц №37: Биохимийн хагас автомат анализаторийн урвалж бодис</b></p> <p><b>Багц №38: Эмгэг судлалын бодисууд</b></p> <p><b>Багц №39: Тэжээлт орчин</b></p> <p><b>Багц №40: Антибиотикийн диск</b></p> <p><b>Багц №41: Бактериологийн бүрэн автомат анализаторийн диск</b></p>
<b>ТШЗ 1.5</b>	<p>Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:</p> <p><b>Дотоодын багц №11: Нэг удаагийн тариур</b></p>
<b>ТШЗ 1.6</b>	<p>Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: <b>“Үгүй”</b></p>
<b>ТШЗ 2.1</b>	<p>Санхүүжилтийн эх үүсвэр нь: Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам” болон Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөр</p>

Нийт төсөвт өртөг: **5,049,551,435 / Таван тэрбум дөчин есөн сая таван зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун гучин таван/ төгрөг**

Д/Д	Дүн /тоогоор/	Дүн /үсгээр/
Багц-1	4,266,420	/Дөрвөн сая хоёр зуун жаран зургаан мянга дөрвөн зуун хорин/ төгрөг
Багц-2	25,495,000	/Хорин таван сая дөрвөн зуун ерэн таван мянга/
Багц-3	153,925,275	/Нэг зуун тавин гурван сая есөн зуун хорин таван мянга хоёр зуун далан таван/ төгрөг
Багц-4	65,191,300	/Жаран таван сая нэг зуун ерэн нэгэн мянга гурван зуун/ төгрөг
Багц-5	127,646,850	/Нэг зуун хорин долоон сая зургаан зуун дөчин зургаан мянга найман зуун тавин/ төгрөг
Багц-6	66,414,600	/Жаран зургаан сая дөрвөн зуун арван дөрвөн мянга зургаан зуун/ төгрөг
Багц-7	233,318,700	/Хоёр зуун гучин гурван сая гурван зуун арван найман мянга долоон зуун/ төгрөг
Багц-8	60,043,570	/Жаран сая дөчин гурван мянга таван зуун далан/ төгрөг
Багц-9	194,365,340	/Нэг зуун ерэн дөрвөн сая гурван зуун жаран таван мянга гурван зуун дөчин/ төгрөг
Багц-10	106,252,000	/Нэг зуун зургаан сая хоёр зуун тавин хоёр мянган/ төгрөг
Багц-11	126,218,000	/Нэг зуун хорин зургаан сая хоёр зуун арван найман мянган/ төгрөг
Багц-12	56,872,250	/Тавин зургаан сая найман зуун далан хоёр мянга хоёр зуун тавин/ төгрөг
Багц-13	94,204,000	/Ерэн дөрвөн сая хоёр зуун дөрвөн мянган/ төгрөг
Багц-14	87,294,670	/Наян долоон сая хоёр зуун ерэн дөрвөн мянга зургаан зуун далан/ төгрөг
Багц-15	184,593,000	/Нэг зуун наян дөрвөн сая таван зуун ерэн гурван мянган/ төгрөг
Багц-16	55,751,200	/Тавин таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун/ төгрөг
Багц-17	75,329,000	/Далан таван сая гурван зуун хорин есөн мянган/ төгрөг
Багц-18	48,292,000	/Дөчин найман сая хоёр зуун ерэн хоёр мянган/ төгрөг
Багц-19	8,644,000	/Найман сая зургаан зуун дөчин дөрвөн мянган/ төгрөг
Багц-20	37,778,000	/Гучин долоон сая долоон зуун далан найман мянган/ төгрөг
Багц-21	111,118,200	/Нэг зуун арван нэгэн сая нэг зуун арван найман мянга хоёр зуун/ төгрөг
Багц-22	14,170,000	/Арван дөрвөн сая нэг зуун далан мянган/ төгрөг
Багц-23	228,403,500	/Хоёр зуун хорин найман сая дөрвөн зуун гурван мянга таван зуун/ төгрөг
Багц-24	14,392,360	/Арван дөрвөн сая гурван зуун ерэн хоёр мянга гурван зуун жаран/ төгрөг
Багц-25	33,324,800	/Гучин гурван сая гурван зуун хорин дөрвөн мянга найман зуун/ төгрөг
Багц-26	774,170,000	/Долоон зуун далан дөрвөн сая нэг зуун далан мянган/ төгрөг

	Багц-27	32,810,000	/Гучин хоёр сая найман зуун арван мянган/ төгрөг
	Багц-28	60,511,850	/Жаран сая таван зуун арван нэгэн мянга найман зуун тавин/ төгрөг
	Багц-29	32,386,600	/Гучин хоёр сая гурван зуун наян зургаан мянга зургаан зуун/ төгрөг
	Багц-30	30,075,200	/Гучин сая далан таван мянга хоёр зуун төгрөг
	Багц-31	91,318,000	/Ерэн нэгэн сая гурван зуун арван найман мянган/ төгрөг
	Багц-32	79,344,000	/Далан есөн сая гурван зуун дөчин дөрвөн мянган/ төгрөг
	Багц-33	486,781,200	/Дөрвөн зуун наян зургаан сая долоон зуун наян нэгэн мянга хоёр зуун/ төгрөг
	Багц-34	949,575,250	/Есөн зуун дөчин есөн мянга таван зуун далан таван мянга хоёр зуун тавин/ төгрөг
	Багц-35	82,872,000	/Наян хоёр сая найман зуун далан хоёр мянган/ төгрөг
	Багц-36	53,700,000	/Тавин гурван сая долоон зуун мянган/ төгрөг
	Багц-37	28,672,000	/Хорин найман сая зургаан зуун далан хоёр мянган/ төгрөг
	Багц-38	31,455,000	/Гучин нэгэн сая дөрвөн зуун тавин таван мянган/ төгрөг
	Багц-39	16,649,000	/Арван зургаан сая зургаан зуун дөчин мянган/ төгрөг
	Багц-40	23,827,300	/Хорин гурван сая найман зуун хорин долоон мянга гурван зуун/ төгрөг
	Багц-41	62,100,000	/Жаран хоёр сая нэг зуун мянган/ төгрөг
	Нийт дүн	<b>5,049,551,435</b>	<b>/Таван тэрбум дөчин есөн сая таван зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун гучин таван/ төгрөг</b>

## Б. АГУУЛГА

<b>ТШЗ 8.1</b>	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “УБТЗ”-ын “Төв Эмнэлэг”</p> <p>Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 27-р хороо, Жасрайн гудамж, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “УБТЗ”-ын “Төв Эмнэлэг”</p> <p>Утасны дугаар: 21-244993</p> <p>Цахим шуудангийн хаяг: <a href="mailto:tungaa.ubtz@gmail.com">tungaa.ubtz@gmail.com</a></p> <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө байна.</p> <p>Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.</p>
<b>ТШЗ 11.1</b>	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: <b>“Үгүй”</b>

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

<b>ТШЗ 12.2</b>	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: <b>“Монгол хэл”</b>
-----------------	--

	<p>Гадаад хэл дээрх бүх материалыг Монгол хэл дээр орчуулсан орчуулгын хамт ирүүлнэ.</p> <p>Тендерийн материалыг Монгол хэл дээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТШЗ 15.1</b>	Хувилбарт санал ирүүлэхийг: <b>“Зөвшөөрөхгүй”</b>
<b>ТШЗ 16.2</b>	<p>Сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: Шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүхийн тусгай архивын лавлагаа</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт ирүүлнэ.</li> </ul> <p><b>Хэрэв гадаадын этгээд оролцох бол:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Арбитрын эсхүл шүүхийн тодорхойлолт</li> <li>2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт тус тус ирүүлнэ.</li> </ol> <p>Гадаадын этгээд нь тус тодорхойлолтуудыг апостиль гэрчилгээгээр баталгаажуулан ирүүлнэ.</p> <p><b>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</b></p>
<b>ТШЗ 16.3</b>	Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх: <b>“Эрхтэй”</b>
<b>ТШЗ 17.4</b>	<p>Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: <b>“Тийм”</b></p> <p>Техникийн тодорхойлолт хэсэгт багцын нийтэд болон багц доторх нэг бүрт <b>“Дээж ирүүлэх”</b> гэж бичсэн эм, эмнэлгийн хэрэгсэлд дээж ирүүлнэ.</p> <p>Багц 17-д дээжийг ирүүлэхдээ <b>“Үндэсний үйлдвэрийн бодис”-оос 5 ширхэгээс доошгүй, “Ариутгал халдваргүйтэл”-ийн савлагаа ихтэй бодисын нэр төрөл бүрээс 1 ширхэгийг тус тус ирүүлнэ.</b></p> <p><b>(Дээж шаардсан багцуудад дээж хүлээлгэн өгөхдөө Тендерт гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд дээжид ирүүлсэн эм эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэхийг баталсан албан бичиг дээжийн хамт ирүүлнэ)</b></p> <p><b>Дээж ирүүлэх эцсийн хугацаа:</b> Тухайн багцад санал болгож буй эмнэлгийн хэрэгслийн дээжийг тендер нээх 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10:00 хүртэлх хугацаанд хүлээн авна.</p> <p><b>Дээж ирүүлэх хаяг:</b> Баянгол дүүрэг, 27 хороо Жасрайн гудамж Монгол-Оросын ХНН УБТЗ-ын Төв эмнэлгийн Эм зүйн тасгийн эрхлэгчийн өрөөнд ирүүлнэ.</p> <p>Утасны дугаар 21-244993</p>
<b>ТШЗ 17.6</b>	<p>Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: <b>“Тийм”</b></p> <p>Хүйтэн хэлхээний зарчмаар хадгалах, зөөвөрлөгдөх эм тарианы агуулах болон зөөвөрлөх тоног төхөөрөмжийн зураг, хадгалалт тээвэрлэлтийн явцын хяналтыг батлах баримт /Жишээ нь хөргөгчний хэмийн заалтын тэмдэглэгээ г.м/ Багц:2, 9, 10, 13, 30, 32, 33, 34, 36, 37, 39, 40, 41 дугаар багцууд орно.</p>



<p><b>ТШЗ 18.1</b></p>	<p>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: Шаардахгүй</p> <p>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: <b>“Шаардлагатай”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>2021, 2022 оны аль нэг жилд тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50%-с багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь 1 удаа нийлүүлсэн байх шаардлагатай</b> (Жич: хэрэв 1-с дээш тооны багц тендерт оролцох бол тухайн багцуудын төсөвт өртгийн нийлбэр үнийн дүнгийн 50%-иас багагүй байна)</li> <li>- Ижил төстэй ажил төстэй ажил гэдэгт тухайн багцад орсон нэр төрлийн бараа нийлүүлснийг ойлгоно.</li> <li>- Бараа нийлүүлсэн гэрээ ба гэрээ дүгнэсэн акт, төлбөрийн и-баримт хамт ирүүлнэ.</li> </ul> <p>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: <b>“Шаардана”</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүйтэн хэлхээний зарчмаар хадгалах, зөөвөрлөгдөх эм тарианы агуулах болон зөөвөрлөх тоног төхөөрөмж, машин техникийн зураг, гэрчилгээ /Тээврийн хэрэгслийн гэрчилгээг ирүүлэх/.</li> <li>- Түрээс бол түрээсийн гэрээг автомашины фото зургийн хамт хавсаргах</li> </ul> <p>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: Шаардана.</p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Борлуулалтын орлогын хэмжээ:</b> 2021, 2022 оны аль нэг жилийн борлуулалтын орлого нь тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50%-иас багагүй байна. (Жич: хэрэв 1-с дээш тооны багц тендерт оролцох бол тухайн багцуудын төсөвт өртгийн нийлбэр үнийн дүнгийн 50%-иас багагүй байна)</li> <li>- Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</li> </ul>
<p><b>ТШЗ 18.2</b></p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: <b>“Шаардана”</b>.</p> <p><b>Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлийг оролцох багцын дагуу ирүүлнэ.</b></p> <p>Дээрх багцуудад шаардлагатай тусгай зөвшөөрлийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахимаар шалгах бөгөөд цахим тендерийн материалд хавсарган ирүүлнэ.</p>
<p><b>ТШЗ 19.1</b></p>	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: <b>“Тийм”</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээ: Тухайн багцын батлагдсан төсөвт өртгийн 50%-с багагүй байна. (Жич: хэрэв 1-с дээш тооны багц тендерт оролцох бол тухайн багцуудын төсөвт өртгийн нийлбэр үнийн дүнгийн 50%-с багагүй байна).</li> </ol>

	<p>Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын дансны үлдэгдэл (Харилцагч бүх банкны)</li> <li>- Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /Банкны зээлийн нөхцлийн дагуу, судлагдаж байгаа болон судалж үзээд зээл олгох боломжтой тухай гэсэн тодорхойлолтыг хүчинтэйд тооцохгүй/</li> <li>- Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;</li> </ul> <p>2. Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Оролцогч “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг <a href="http://www.sainscore.mn">www.sainscore.mn</a>, <a href="http://www.burenscore.mn">www.burenscore.mn</a> хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.</p> <p>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021, 2022 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн <a href="http://www.e-balance.mof.gov.mn">www.e-balance.mof.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>
<p><b>ТШЗ 20.1</b></p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: <b><u>“Туйм”</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгууллагын тухай товч танилцуулга ирүүлнэ.</li> <li>2. Эм, эмнэлэгийн хэрэгслийн үнийн задаргаа ба бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>3. Тендер нээсэн өдрийн байдлаар Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай. /Татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-ээр дамжуулан шалгана./</li> <li>4. Нийлүүлэх эм, эмнэлэгийн хэрэгслийг дагалдаж ирэх чанарын болон гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. Дээж ирүүлсэн багцын эм, эмнэлэгийн хэрэгслийн тус бүрийн үйлдвэрлэгч, гарал үүслийг тодорхой бичиж ирүүлэх.</li> <li>5. Үйлдвэрлэгчээс гаргасан эмийн найрлага, хэрэглэх заавар, эмнэлэгийн хэрэгслийн техникийн тодорхойлолтыг хавсаргаж ирүүлнэ.</li> <li>6. “УБТЗ” ХНН-ийн зүгээс тендерт оролцогчийн тендерт оролцогчийн татвар, банк, нийгмийн даатгалын хэлтэс, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.</li> <li>7. Тендерий багцад шалгарсан тохиолдолд тухайн гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан эм, эмнэлэгийн хэрэгслийг захиалагчид</li> </ol>

	<p>эм, эмнэлэгийн хэрэгслийг нийлүүлэх шаардлага хуваарийн дагуу ирүүлэх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>8. Бараа бүтээгдэхүүний баталгаат хугацаа: Нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний баталгаат хугацаа нь үйлдвэрлэгчийн заасан баталгаат хугацааны 65%-иас доошгүй байх бөгөөд худалдан авагч талд хүлээлгэн өгөх хүртэлх хугацааны тээвэрлэлтийн гэмтэл, чанар, бүрэн бүтэн байдлын баталгааг Нийлүүлэгч ханган бүрэн хариуцна.</p> <p>9. Нийлүүлэгдсэн эм, эмнэлэгийн хэрэгсэл нь захиалагчийн захиалсан эм, эмнэлэгийн хэрэгсэл таарч тохирохгүй эсхүл гэмтэлтэй ирсэн бол 7 хоногт буцааж сольж өгөхийг зөвшөөрсөн албан бичиг ирүүлнэ.</p> <p>10. Үнийн саналыг маягтын дагуу баталгаажуулж ирүүлнэ.</p> <p><b>Жич: ТӨХ-д заасан материалуудын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Мөн ТӨХ-д шаардагдаагүй үнэлгээнд нөлөөлөхүйц бус баримт бичгийг нэмэлтээр ирүүлсэн тохиолдолд үнэлгээнд харгалзахгүй болно.</b></p> <p>-Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: <b>“Шаардахгүй”</b></p>																																								
ТШЗ 21.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: <b>“Тохируулахгүй тогтмол байна”</b>																																								
